ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 22 өдөр Дугаар 2/07 Сэврэй сум

Сумын 2025 оны хөгжлийн жилийн
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалтыг тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Сэврэй сумын 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Батсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ч.ОГТБИШ

7462407035

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 2/07
дугаар тогтоолын хавсралт

СЭВРЭЙ СУМЫН 2025 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сэврэй сумыг 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний зорилт нь Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Өмнөговь аймгийн Засаг дарга болон Сэврэй сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Өмнөговь аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нэгдсэн бодлогоор хамтарч дэмжлэг үзүүлэн, Сумын иргэд, хүүхэд, залуус олон талт боловсролыг хүртээмжтэй олох нөхцөлийг бүрдүүлэн хүн бүрийн эрүүл мэндийг хамгаалах, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл зөв дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэх, хүрээлэн буй орчны унаган төрхийг хэвээр хадгалан үлдээх, мэдээлэл технологийн дэвшил, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарыг дэмжиж тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгоход оршино.

Сайншанд 2024.12.22

Д/д	ЗДҮХ-ийн заалт	Зорилт арга хэмжээнүүд	Хэмжих нэгж шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Нийт төсөвт өртөг /сая төг/	Үүнээс санхүүжилт /сая төгрөг/					Хариуцах байгууллага, Албад мэргэжилтэн
						Улсын төсөв	Орон нутгийн төсөв				
							Аймгийн орон нутгийн төсөв	Сумын орон нутгийн төсөв	Орон нутгийн хөгжлийн сан /сая/	Төсөл Хөтөлбөр	
Нэг. Нийгмийн бодлогын хүрээнд:											
1.1 Эрүүл мэндийн салбарын чиглэлээр											
1	30	Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх. Сумын **“Эрүүл иргэн”** дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Хөтөлбөр боловсруулж батлуулах	100	10.0			10.0			ЭМТ
2	29	Эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, хүн амыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлж, өвчнийг эрт илрүүлэх бодлогыг хэрэгжүүлэн, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог тогтмол хийж нотолгоонд болон хувь хүний онцлогт тохируулан урьдчилан сэргийлдэг эрүүл мэндийн үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгоно.	үйл ажиллагааны хэрэгжилтээр		0.0						ЭМТ

3	39	Хүн амын дунд Гепатит вирусийн халдварын эрт өртөх эрсдэл бүхий зорилтот бүлгийг мэдээллээр хангаж, эрт илрүүлэгийг хийх замаар аймгийн "Эрүүл элэг" хөтөлбөрийг суманд хэрэгжүүлэн эрт илрүүлж эмчлэн эрүүлжүүлэх замаар элэгний шалтгаант өвчлөл эндэгдлийг бууруулах	Өмнөх оноос 5 хувиар нэмэгдүүлэх.	95	0.0						ЭМТ
4	37	Иргэдийн амны хөндий, шүдний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн, гадаад дотоодын олон улсын сайн дурын байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлж ажиллана.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	100	0.0						ЭМТ
5	37	Сумын ерөнхий боловсролын сургууль болон эрүүл мэндийн төвд шүд угаах хэсгийг байгуулж, байнгын ашиглалтад оруулах	Тоо-2	100	0.0						ЭМТ
6	34	Эх хүүхдийн эрүүл мэндийг тэргүүлэх чиглэл болгон, аймгийн "эх хүүхдийн эрүүл мэнд" хөтөрбөрийг хэрэгжүүлэн чанар хүртээмжийг сайжруулан эх хүүхдийн өвчлөл эндэгдлийг бууруулна.	эх хүүхдийн өвчлөл буурсан байна.		0.0						ЭМТ
7	35	Бага насны хүүхдийг эрүүл чийрэг байхад зориулагдсан хүүхдийн сувиллыг ажиллуулж, сувилал чийрэгжүүлэх ажлыг 0.6-2 насны хүүхдүүдийн дунд зохион байгуулж, Сүү тараг хөтөлбөрийг хэрэгжүүлэн хүүхдийн өвчлөлийг бууруулна.	Хамрагдах хүүхдийн тоо	30, 100	0.0						ЭМТ
8	36	Сумын хэмжээнд 18 хүртэлх насны хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах/жаргалтай ирээдүй хүүхдийн үзлэгийг зохион байгуулах/.	Хамрагдах хүүхдийн тоо		0.0						ЭМТ
9	38	Хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо эмчилгээг зохион байгуулах /18-аас дээш насны иргэдийг эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамруулах/.	Хамрагдах иргэдийн тоо		0.0						ЭМТ
10	38	Иргэдийн дундах осол гэмтлийн гаралтад дүн шинжилгээг хийж осол гэмтлээс сэргийлэх ажлыг зорилтот бүлэгт үе шаттайгаар зохион байгуулах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						ЭМТ
11	40	Сумын эрүүл мэндийн төвд сэргээн засах, уламжлалт эмчилгээг өргөжүүлэн чанар, тоо хүртээмжийг нэмэгдүүлэх .	Хамрагдсан иргэдийн тоо	30	0.0						ЭМТ
12	33	Орчин үеийн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэн оношилгооны лабораторийн хүчин чадлыг сайжруулан, сумандаа төрөл бүрийн шинжилгээг өгөх боломж нөхцөлийг хангаж ажиллан явуулын үзлэг шинжилгээний ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						ЭМТ
13	30	Иргэдийн дунд хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг өрнүүлж Эртэч Сэврэй аяныг зохион байгуулах.	Арга хэмжээний тоо	1	0.0						Соёл
14	41	Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлж, эмийн эргэлтийн сангийн зайлшгүй шаардлагатай эмийн хангалтыг 90 хувьд хүргэнэ.	Ү.З.Ш эмийн хангалт	90	0.0						Нөөөт говь

15	42	Эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн даатгалаар үйлчлэх үйлчилгээний нэр төрлийг олшруулж, гүйцэтгэлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх.	Даатгалд хамрагдагсдын хувь	70	0.0						ЭМТ
16	45	Мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн ханган эмч, мэргэжилтнүүдийг сурч, боловсрох нөхцөл боломжийг бүрдүүлнэ. Мэргэшсэн сургалтад мэргэжилтэнгүүдийг хамруулах.	Боловсон хүчний хангалт	1	0.0						ЭМТ
17	32	Багийн эмнэлэг болон багийн эмчийн ажиллах нөхцөл бололцоог нэмэгдүүлэн багийн эмчийн шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл тоног төхөөрөмжөөр хангана.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	4 удаа	0.0						ЭМТ
18	37	Сумын эмнэлгийн яаралтай түргэн тусламжийн үйлчилгээний чанар, хүртээмж, техникийн хангалтыг сайжруулж туулах чадвар сайтай түргэн тусламжийн авто машинаар хангана.	тоо	1	160.0		160.0				ЭМТ
19	31	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээг нэмэгдүүлэн, сувиллыг тогтмол зохион байгуулна.	тоо	30	0.0						
	Дүн				**170.0**	**0.0**	**160.0**	**10.0**	**0.0**	**0.0**	
1.2 Боловсролын салбарын чиглэлээр											
20	17	Сургуулийн өмнөх боловсролын сайжруулсан хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хүүхэд бүрийн хөгжлийн ахицыг тооцон судалгаанд суурилсан үйл ажиллагаагаар боловсролын үйлчилгээг чанаржуулна.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						СӨБ
21	11	Хамран сургах тойргийн 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд заавал 100 хувь хамруулна.	Хамран сургалт, явуулын сургалт	100	0.0						СӨБ
22		Хүүхдэд Монгол ёс заншлаа дээдэлсэн, зөв төлөвшил хандлагатай, эх оронч, эрх чөлөөт, сэтгэлгээтэй, үндэсний бахархлыг төлөвшүүлсэн аймгийн "Говийн ирээдүй хүүхэд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	Хамрагдах хүүхдийн тоо	100	0.0						СӨБ
23		Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багийг чанартай ажиллуулан Хүүхэд хамгааллын тухай хууль, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн ажиллах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						СӨБ
24	18	Багш нарын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр мэргэжлийн сургалтад хамруулах. Хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлнэ.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						СӨБ

25	13	2-5 насны хүүхдийн математик инженерчлэл, техник сэтгэлгээг хөгжүүлэх төрөл бүрийн сургалтыг чанартай зохион байгуулна.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						СӨБ
26		Эцэг эх , олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн бага насны цогц хөгжлийн талаар нөлөөллийн ажлуудыг зохион байгуулна.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						СӨБ
27		"Өдөр бүр сүү" арга хэмжээг нутгийн захиргааны байгууллага, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой хамтран хэрэгжүүлж хүүхдийн өсөлт, эрүүл мэндийг дэмжинэ.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						СӨБ
28		Бага, дунд боловсролын салбарын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэн сургалтын чанарыг дээшлүүлэх.	Өмнөх жилийнхээс ахиулах	1-2 хувь	0.0						ЕБС
29		Хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор ахмад багш Ж.Буян-Өлзийн нэрэмжит төрөл мэргэжлийн олимпиадын сорилго Математикийн олимпиадыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	1 удаа	0.0						ЗДТГ, ЕБС
30		"Зөв сайхан бичигтэн-Сэврэй" аяныг үргэлжлүүлэн өрнүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	205 сурагч 32 багш	0.0						ЕБС
31		Цагаан суварганы хүчтэн бөхийн дэвжээний үйл ажиллагааг тогтмолжуулж, тамирчдыг бэлтгэх гэрээт дасгалжуулагч ажиллуулан, орон нутгийн чанартай **"Сэврэйн цом"** тэмцээнийг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	1, 1	0.0						ЗДТГ, ЕБС, СОЁЛ,
32		Сумын Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах одон бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	1	0.0						
33		Сэврэй сумын экосистем, зэрлэг байгалийн танин мэдэхүйн хөтөлбөрийг хэрэгжүүлж, аялалт хичээл, сургалт зохион байгуулах. Байгаль хамгаалах сурагчдын "Ирвэс" үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.	Аяллын тоо	1	0.0						ЗДТГ,ЕБС
34		Хүүхэд залуучууд, өсвөр насныхны авьяас чадварыг хөгжүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн дотоод нөөц бололцоог түшиглэн хичээлээс гадуурх дугуйлан, клубуудын хичээл сургалтуудыг чанартай явуулах	Хамрагдах хүүхдийн тоо, Дугуйлангийн тоо	ЕБС-204 сурагч, 12	0.0						ЕБС

35		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах ажлыг сургууль цэцэрлэгийн хэмжээнд хэрэгжүүлж сурч боловсрох орчин нөхцөлийг сайжруулах, бусад сургуулиас туршлага судлах.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						СӨБ, ЕБС
36		Эрүүл мэндийн хичээлийг чанартай хүртээмжтэй зохион байгуулж өсвөр үеийнхний бэлгийн боловсролыг дээшлүүлнэ.			0.0						ЕБС, ЭМТ
37		Насан туршийн боловсролын үйл ажиллагааны хамрах хүрээг өргөтгөн, чанар хүртээмжийг нэмэгдүүлж бүх насны иргэд байнга сурч боловсрох, шинэ мэргэжил чадвар олж авах боломжоор ханган, төрөл бүрийн сургалтуудыг зохион байгуулж иргэдийг мэдлэг чадвар эзэмшүүлнэ.	Сургалтын тоо хамрагдсан иргэд	4, 120	0.0						ЗДТГ, ЕБС, СОЁЛ,ЭМТ,СӨБ
38		Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, эцэг эх, багш, хүүхдийн гуравласан холбоог сайжруулж олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр		0.0						НБМ
39		Орон нутгийн харьяат шаардлагатай мэргэжлээр дотоод гадаадын сургуульд суралцаж буй оюутан, залуус, боловсон хүчнүүдийг төрөл бүрийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжоор ханган, Малын эмч, мал эмнэлгийн чиглэлээр суралцаж байгаа оюутныг эх нутагтаа эргэн ирж ажиллах нөхцөл бололцоог бодлогоор дэмжинэ.	Хамрагдах оюутны тоо	6	0.0						НБМ
40		**“Сайн багш-оюунлаг сурагч”** хөтөлбөрийн хүрээнд суманд ажиллаж буй багш нарыг гадаад, дотоодод сурах, мэргэжил дээшлүүлэх боломжоор ханган. Багш, боловсролын салбарын ажилтан, албан хаагчдын мэдлэг ур чадвар, заах аргаа тасралтгүй ахиулах нөхцөл бий болгоно.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	1	40.0			40.0			СӨБ, ЕБС
41	1	Сэврэй сумын 20 дугаар цэцэрлэгт их засвар хийх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	1152.0		1152.0				ЗДО
42	2	Сэврэй сумын дотуур байрны барилгын их засвар хийх			408.4		408.4				ЗДО
	Дүн				**1600.4**	**0.0**	**1560.4**	**40.0**	**0.0**	**0.0**	
1.3 Соёл, спортын салбарын чиглэлээр											
43	23	Соёлын үйлчилгээг ард иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэж, соёлын өвийн илрүүлэлт, хадгалалт хамгаалалтыг сайжруулна.	Үйлчилгээний тоо	4	0.0						Соёлын төв
44		Тэмдэглэлт баяр ёслол, залуу гэр бүлүүдийн хуримын ёслол, ахмадын баяр, залуучуудын чуулга уулзалт, малчдын зөвлөгөөн, сумын аварга шалгаруулах урлаг, спортын уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулна.	Тогтоосон газрын тоо	5	0.0						Соёлын төв

45		**“Ахмадын сургааль алтнаас үнэтэй”** хөтөлбөр хэрэгжүүлж, үндэсний өв соёл, урлаг, амьдрах арга ухаанд суралцах сургалтын агуулгыг бүрдүүлж амьдралын хэв маягаа сайжруулах сургалтуудыг ахмадуудыг түшиглэн зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	3	30.0			30			НБМ
46		Сумын музейн сан үзмэрийг 5 -аас доошгүй үзмэрээр баяжуулж, үзэгчдийн тоог нэмэгдүүлэх, биет бус өв тээгч 2-ийг бүртгэх.	бүртгэсэн үзмэр, өвийн тоо	5 үзмэр, 2 өв	0.0						Соёлын төв
47		Номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн фондын баяжилтыг хийж,	номын тоо, уншигчийн тоо	5 , 100	0.0						Соёлын төв
48		Ажилтан албан хаагчдын мэргэжил, ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулах	Албан хаагчдын тоо	5	0.0						Соёлын төв
49		Бие бялдрын сорилд иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						Соёлын төв, НТБагш
50		Залуучуудад зориулсан сургалт нөлөөлөл, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						Соёлын төв,
	Дүн				**30.0**	**0.0**	**0.0**	**30.0**	**0.0**	**0.0**	
1.4 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалалын чиглэлээр											
51	102	**“Зөв бүхэн- Зөвхөн манай гэр бүлээс”** дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.			25.0			25.0			НБМ
52	49	Ажлын байр нэмэгдүүлэн, өрхийн орлогыг өсгөх замаар хүртээмжтэй эдийн засаг бий болгоно. Иргэдийн мэдлэг, ертөг шингэсэн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ эрхлэх орчинг бүрдүүлж, зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлнэ улмаар дундаж давхаргыг тэлнэ. Сумын иргэдийг ажлын байраар хангах, өрхийн орлого нэмэгдүүлэх зорилгоор **“Хөдөлмөрч Сэврэйчүүд”** дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. Гэр бүл болон иргэд хамтран нийгэмд хорших маягаар хөдөлмөрлөх, өөрийгөө хөгжүүлэх санал санаачилгыг дэмжинэ.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	25.0			25.0			ХХҮМ
53		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалт арга хэмжээ, төсөл хөтөлбөр, эрүүл мэндийн үзлэгт шинжилгээнд хамруулан өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжоор дэмжин ажиллах	хамрагдагсдын тоо	Сургалт 1, бусад 20	0.0						ХХҮМ

54		Ахмад настан иргэдийг амралт сувилалд амрахад дэмжлэг үзүүлэн, ахмад настанд хүргэх нийгмийн халамжийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн ахмадын байгууллагыг дэмжин ажиллана.	хамрагдагсдын тоо	15	0.0						ХХҮМ
55		Ажилд зуучлах үйлчилгээг эрчимжүүлж, ажил хайгч иргэдийг бүртгэлийн нэгдсэн системд бүртгэн иргэдийг байнгын болон түр ажлын байранд зуучилна.	Ажлын байрны тоо	10							ХХҮМ
56		Залуучууд болон зорилтот бүлгийн иргэдийг эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжихэд чиглэсэн сургалт арга хэмжээг зохион байгуулах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	2 иргэн	0.0						ХХҮМ
57		Сумын төвийн болон хөдөөгийн нийт өрхөд хүрч ажиллан нийгмийн даатгалын хуулиудыг сурталчилж нийгмийн даатгалын талаарх иргэдийн ойлголтыг сайжруулан даатгалд хамруулах хүрээг өргөтгөн нийгмийн даатгалын шимтгэл төлөх даатгуулагчийн тоог өмнөх оноос 5 хувиар нэмэгдүүлнэ.	хамрагдагсдын хувь	5	0.0						НДБ
	Дүн				**50.0**	**0.0**	**0.0**	**50.0**	**0.0**	**0.0**	
Хоёр. Эдийн засгийн бодлогын хүрээнд											
2.1 Төсөв санхүүгийн чиглэлээр											
58		Төсвийн тухай болон шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн ажиллан, төсвийн урсгал зардлыг зохистой түвшинд хязгаарлаж, төсвийн тогтвортой иж бүрэн үнэн зөв ил тод зохистой хариуцлагатай байх зарчмыг үргэлжлүүлэн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг 99 хувьд хүргэнэ.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						СА
59		Орон нутгийн болон төсөвт байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлыг идэвхжүүлэн, өмч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг нэмэгдүүлж эд хөрөнгийн тооллого тооцооны чанарыг сайжруулан ИТХ-ын төсөв санхүүгийн хорооноос хяналтын тооллого зохион байгуулах.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2 удаа	0.0						СА
60		Орон нутагт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын цаашид ашиглах ашиглалтад анхаарч ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр		0.0						СА
61		Орон нутгийн хөгжлийн санг иргэд олон нийтийн оролцоотойгоор төлөвлөж зарцуулан, хөндлөнгийн хяналтыг сайжруулна	төсөл арга хэмжээ	100	0.0						СА
62		Худалдан авах ажиллагааг ил тод, хуулийн дагуу явуулж үнэлгээний хороонд А-3 гэрчилгээтэй хүнийг ажиллуулан, А-3 гэрчилгээтэй хүний тоог нэмэгдүүлнэ. Байгууллага бүр 2-оос доошгүй хүнийг сургах.	Нэмэгдэх А-3 сертификаттай иргэдийн тоо	5 хүн	0.0					0.0	СТСМ

63		Иргэд олон нийтийн санхүүгийн мэдлэг, оролцоог сайжруулах, хүүхэд, залуучуудад бага наснаас нь санхүүгийн боловсрол олгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж	Арга хэмжээний хэрэгжилт	хувь	0.0						СА
64		Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн "Нутгийн дэм" хөтөлбөрийг хэрэгжүүлэх,	Олгосон албан хаагчийн тоо, мөнгөн дүн	тоо	0.0						СА
65		Төрийн албан хаагчдыг орон нутагт ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор улсын төсвийн байгууллагын албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох	Хамрагдах албан хаагчид	тоо	0.0						СА
66		Татвар төлөгчдөд албан татвар ногдуулалт, тухайн татварыг төлснөөр цаашид гарах үр ашиг, ач холбогдлыг сурталчлан таниулах, татвар төлөгч нарыг уриалах арга хэмжээ "Татвар төлөгчдийн өдрүүд-2025" арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	0.0						ТУБ
	Дүн				**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	
2.2 Хүнс хөдөө аж ахуй, Үйлдвэрлэл худалдааны салбарын чиглэлээр											
67	55	Мал сүргийг халдварт паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж малын хашаа хорооны ариутгал халдваргүйжүүлэлт хийх.	Нийт мал сүрэг	100	0.0						ТЗ
68	51	**"Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих"** дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж сумын худалдаа үйлчилгээний бизнес эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	1 удаа	40.0			40.0			ХААТ, БЗД нар
69	56	Малжуулах төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж хяналт тавин ажиллана. Сүргийн бүтцийг сайжруулах талаар малчдыг мэдээллээр хангах.	хамрагдсан өрх, малын тоо	3, 150	0.0						ХААТ
70	54	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн хийцтэй худаг гаргах, инженерийн хийцтэй хуучин худгийг засварлаж, тоноглох	Худгийн тоо	4 шинэ, 2 засвар	100.0		100.0				ХААТ
71	58	Тэмээн сүргээ төлөөр өсгөсөн малчин өрхөд мөнгөн урамшуулал олгох арга хэмжээг үргэлжлүүлж, тэмээн сүргийн амьдын үнэлэмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч урьд жилүүдэд хэрэгжүүлж ирсэн тэмээний баяр арга хэмжээг зохион байгуулна.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	1 удаа ботгоны тоогоор	0.0						ХААТ ЗДТГ
72	53	"Чинээлэг малчин" хөтөлбөрийн хүрээнд малчдын уулзалт арга хэмжээ, малчдын зөвлөгөөн, сумын мянгатын зөвлөгөөн, урлаг спортын арга хэмжээ зохион байгуулах.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	1 удаа	0.0						ХААТ ЗДТГ

73		Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	1 удаа	0.0						ХЖДҮХА ХМ
74	59	Хүлэмжийн аж ахуйн эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж, зорилтот бүлгийн иргэдийг газар тариалан эрхлэхийг бодлогоор дэмжинэ.	Хүлэмжийн тоо	2	0.0						ХААТ
75	51	100 эхээс хамгийн олон төл бойжуулсан малчин эзэгтэйг төрөл тус дээр нь шалгаруулж урамшуулах.	5-н төрлөөр, Төрөл тус бүр	6 өрх	0.0						ХААТ ЗДТГ
76	87	Сум орон нутагт уламжлал болгон зохион байгуулагддаг хурдан морьдын уралдаан бусад наадмыг хамтран зохион байгуулах.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	3 удаа	5.0				5.0		БЗДарга, ХААТ
77	60	Хүнсний хангамж - аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд Хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулах нөлөөллийн ажиллагаа зохион байгуулах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						ХААТ
78	59	Газар тариалан эрхлэгчдийг бодлогоор дэмжих	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						ХААТ
	Дүн				**145.0**	**0.0**	**100.0**	**40.0**	**5.0**	**0.0**	
2.3 Дэд бүтцийн салбарын чиглэлээр											
79		Сумын Ахмадын өргөөг барьж ашиглалтад оруулах.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	1331.1		1331.1				ЗДО
80		Хоолт багийн төвийн барилга барьж ашиглалтад оруулах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	50.0		50.0				ЗДО
81		Сумын Цагдаагийн хэсгийн барилга барих	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	350.0		350.0				ЗДО
82		Сумын халаалтын системийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор томоохон барилга холбоно.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	150.0		150.0				ЗДО

83		Сумын төвийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл хайгуул судалгааны ажил хийх, нөөц батлуулах, улсын мэдэллийн санд бүртгүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	377.8		377.8				ЗДО
84		Бүйлсэн баг Алагын өндөрт 4g сүлжээ оруулах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	330.0		330.0				ЗДО
85		Хонгорын гол "Нүдэн булаг " төвийг сэргээгдэх эрчим хүчээр хангах 20квт.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	56.3		56.3				ЗДО
86		Соёлын төвийн зураг төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						ЗДО
87		Сайншанд багийн төвийн зураг төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						ЗДО
88		Ахмад настан, хүүхэд, залуучуудын спорт хөгжлийн төвийн зураг төсөв.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						ЗДО
89		Эмч нарын орон сууц, эмийн сангийн барилгын засвар, хуучин эмнэлгийн барилгын засвар хийх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	115.1			115.1			ЗДО
90		Сумын онцгой комиссыг туулах чадвар сайтай авто машинаар хангах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	320.0			320.0			ЗДО
91		Орон нутгийн зам цэвэрлэх машин авах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	65.0			65.0			ЗДО

92		Засмал зам дагуух сумын хилийн цэс газарт тохижилт хийх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	38.7			38.7			ЗДО
93		Сумын төрийн үйлчилгээний автомашины засвар үйлчилгээний автограш барина.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	100.0			100.0			
94		Сумын баяр наадам тэмдэглэн өнгөрүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	5.0				5.00		ЗДО
95		Үйлчилгээний төв бүхий 12 айлын орон сууцны барилга барих	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	750.0				750.00		ЗДО
96		Орон нутгийн өмчит газарт унагалдай, ухдаг трактор авах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	100.0				100.00		ЗДО
97		Сургуулийн биеийн тамирын талбайн эвдэрсэн тоглоомуудыг засварлах,	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	20.0				20.00		ЗДО
98		Сургуулийн багш хөгжлийн төвийг тохижуулах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	55.0				55.00		ЗДО
99		Хонгорын гол руу сумын төвөөс 15квт ын өндөр хүчдэлийн цахилгааны шугам татах ажлыг эхлүүлэх /зураг төсөв боловсруулах/	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	10.0				10		ЗДО
100		Багийн төвийг шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоор хангах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	20.0				20.00		ЗДО

101		Цагаан идээ махны цех тогтмол ажиллуулах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	10.0				10.00		ЗДО
102		Иргэдэд сургалт хийх / гар урлал, оёдол эсгүүр, сийлбэр, хоол үйлдвэрлэл, гэх мэт/	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	8.9				8.90		ЗДО
103		Суманд хууль эрх зүйн танхим байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	10.0				10.00		ЗДО
104		Мал эмнэлгийн үйлчилгээ ,Мал угаалга тарилга туулга вакцинжуулалт халдваргүйжүүлэлт,хороо бууц ариутгах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	4.0				4.000		ЗДО
105		Малчдын гэр бүлийн тогтвортой байдлын талаар сургалт авах Малчдад сургалт,өдөрлөг тэмцээн уралдаан зохион байгуулах /Цагаан идээ боловсруулах, малын эрүүл мэнд, гэр бүлийн харилцаа/	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	10.0				10.0		ЗДО
106		Гүн өрмийн худаг, худгын байшин засварлах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	16.0				16.0		ЗДО
107		Гэмт халдлага, гамшгаас хамгаалах /золбин нохой, галзуу үнэг чоно устгах/	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	10.0				10.0		ЗДО
108		Төв, суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	40.0					40.0	Дэмд-Од ОНӨААТ ҮГ
109		Газрын даамал, багийн Засаг дарга нар хамтран тусгай хамгаалалтай газарт байрших өвөлжөөний гэрчилгээнүүдийг сунгах санлыг болосруулж тусгай хамгаалалтай газрын удирдлагын газарт хүргүүлэх.	Хамрагдах өрхийн тоо								БЗДарга нар
	Дүн				**4352.9**	**0.0**	**2645.2**	**638.8**	**1028.9**	**40.0**	
2.4 Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр											

110		Ногоон сум, аялал жуулчлал хөгжүүлэх дэд хөтөлбөрүүдийг боловсруулан ИТХ-аар батлуулах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	35.0			35.0			БОАХМ
111		Байгаль орчныг хамгаалах тэмдэглэлт өдрүүдийг иргэд, олон нийтийн байгаль хамгаалах мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулах	Арга хэмжээний тоо	4	0.0						БОАХМ
112		Байгаль орчноо хамгаалах үзлийг төлөвшүүлэх “Эх орон - миний говь” танин мэдэхүйн аялал зохион байгуулах	Арга хэмжээний тоо	1	0.0						БОАХМ
113		“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод, бут, жимс жимсгэнийн мод тариалах, цэцэрлэгжүүлэх, сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	1	0.0						БОАХМ
114		Мод тарьж ургуулсан иргэн аж ахуй нэгж байгууллагад урамшуулал олгох	Хамрагдах иргэний тоо	5	0.0						БОАХМ
115		Булаг шандын эхийг хашиж хамгаалах, Бүйлсэн багийн хөв цөөрөм байгуулах	Хашиж хамгаалсан булгийн тоо	1	148.5		148.5				БОАХМ
116		Хонгорын голд хөв цөөрөм байгуулах	Байгуулсан хөв цөөрмийн тоо	1	1258.0		1258.0				БОАХМ
117		Зэрлэг амьтдын амьдрах орчинг сайжруулах биотехникийн арга хэмжээг авах	Арга хэмжээний тоо	1	0.0						БОАХМ
118		Сумын хог хаягдлын төвлөрсөн цэг шинээр байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	1000.0		1000.0				БОАХМ
119		Хонгорын голын элс орчмын байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэн “Алтан элс-Элсэн манханы баяр” арга хэмжээг хамтран зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	1 удаа	250.0		250.0				БОАХМ

120		Хууль бусаар ашигт малтмал олборлож буй газруудад хяналт шалгалт хийж, хариуцлагыг хүлээлгэх, эвдрэлд орсон газруудад нөхөн сэргээлт хийх.	Хяналт шалгалтын тоогоор Нөхөн сэргээгдсэн талбайн хэмжээ	4 10	0.0						БОАХМ
121		Нутгийн өөрөө удирдах ёсны болон төр, захиргааны байгууллагууд, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг аялал жуулчлалын компани, хувираа аялал жуулчлал эрхлэгчдийн хамтын ажиллагааны түншлэлийн хүрээг өргөтгөж "Хонгор аялал"-ыг хамтран зохион байгуулах.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	1	0.0						БОАХМ
122		Сумын цаг уурын ажиглалтыг жилийн турш тасралтгүй явуулж цаг агаарын мэдээгээр иргэдийг хангах.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	1	0.0						ЦУА
	Дүн				**2691.5**	**0.0**	**2656.5**	**35.0**	**0.0**	**0.0**	
Гурав. Төрийн захиргаа, эрх зүйн бодлогын хүрээнд:											
3.1 Төрийн захиргааны чиглэлээр											
123		Ил тод, нээлттэй байдал, иргэдийн оролцоог хангах арга хэмжээг хэрэгжүүлэх, Сум, багийн төвд төрийн үйлчилгээг нэг цэгээс үзүүлэх "Явуулын оффис" ажиллуулах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0	0					ЗДТГ-ын дарга
124	101	Хүний эрхийг дээдэлсэн, иргэдийн оролцоог хангасан, ил тод, ёс зүйтэй, шуурхай төрийн үйлчилгээг оновчтой бодлогоор удирдан, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан төрийн албан хаагчийн сахилга хариуцлага ёс зүй хандлагыг шинэ шатанд гаргаж иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшүүлэн **"Сайн төрийн албан хаагч"** хөтөлбөрийг хэрэгжүүлэн иргэдийн эрэлтийг ханган төрийн албаны явуулын нэг цэгийн үйлчилгээг тогтмолжуулна.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	20.0			20.0			ХЭЗХМ
125	104	Цахим орчны эрх зүйн харилцааг боловсронгуй болгох төрийн мэдээлэл үйлчилгээний и-монголиа, и оффис өмнөговь цахим үйлчилгээнүүдийг хэрэгжүүлэн ил тод, нээлттэй байдал, иргэдийн оролцоог хангана.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						ХЭЗХМ
126	104	Хатан Сэврэйн мэдээ сонин, иргэдэд мэдээлэл хүргэх масс мессеж үйлчилгээг үргэлжлүүлэн ажиллуулна. Сэврэй сумын цахим хуудаснуудыг үргэлжлүүлэн ажиллуулж төрийн үйлчилгээний мэдээ мэдээллийг иргэдэд хүртээмжтэй хүргэж ажиллаж **"Мэдээлэлтэй иргэн хүчирхэг"** дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	10.0			10.0			ХЭЗХМ

127		Авлига, хүнд суртлаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдын хариуцлага, ёс зүйг сайжруулах үйл ажиллагааг бүх шатанд эрчимжүүлж, иргэдийн үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэн өргөдөл, гомдлын шийдвэрлэнэ	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						ХЭЗХМ
128	109	Гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх "Ээлтэй Өмнөговь" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						ХЭЗХМ
129		Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, харилцаа хандлагыг сайжруулах сургалт, "Сахилга хариуцлагын зөвлөгөөн" зохион байгуулах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						ЗДТГ Албан байгуулл агууд
130		Суманд бүх чиглэлээр хэрэгжиж мөрдөгдөж байгаа Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнана.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						ХЭЗХМ
131		Хуулийн этгээдийн бүртгэл, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлээс бусад 8 төрлийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллана	үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0.0						УБ
	Дүн				30.0	**0.0**	**0.0**	**30.0**	**0.0**	**0.0**	
3.2 Хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр											
132		ЗДТГазрын дэргэдэх хяналт шинжилгээ үнэлгээний багийн ажлын төлөвлөгөөг гарган хяналт тавин хэрэгжүүлж, үр нөлөөг дээшлүүлж ажиллана	Хяналт хийх тоо	4	0.0						ХШҮБ
133		ISO стандарт нэвтрүүлсэн ЗДТГ магадлах аудит хийлгэх.	хувь		0.0						ЗДТГ
134		Санхүүгийн алба, Татварын байцаагч, НД-байцаагч нар хамтран төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагуудын хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, зардлын зарцуулалтад хяналт шалгалт тавин, арга зүйн зөвлөгөө өгнө. ИТХ-д Засаг даргын зөвлөлд танилцуулж, иргэдийг мэдээллээр хангана	Хяналт хийх тоо	2	0.0						СА,НДБ, ТУБ
135		Суманд худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдийг НӨАТ-ын баримт олгох. Иргэдэд НӨАТ-ийн хуулийг сурталчлах.	Аж ахуй нэгжийн тоо	10	0.0						ТУБ
	Дүн				**0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	
3.3 Хууль эрх зүйн чиглэлээр											
136		Цагдаагийн хэсгийг түшиглэн иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг сайжруулан, **"Эрх зүйн туслалцаа үзүүлэх"** төв ажиллуулна.	зөрчлийн тоо өмнөх оноос буурах		0.0	0.0					ХЭЗХМ

137		Шинэчлэн батлагдан гарсан хуулиудын талаар иргэдэд мэдээлэл сурталчилгаа хийж гэмт хэрэг зөрчил гарахаас урьдчилан сэргийлнэ	улирал бүр		0.0						ХЭЗХМ
138		Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс иргэд, аж ахуй нэгж байгууллагуудын дунд "Хууль бидний амьдралд", ЕБС-ийн сурагчдын дунд "Ногоон гэрэл цагаан шугам" арга хэмжээг зохион байгуулна	үйл ажиллагааны хэрэгжилтээр		0.0						ХЭЗХМ
139		Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах явдлыг эрчимжүүлж, хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настныг гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн үеийн түр хамгаалах байраар үйлчилнэ.	үйл ажиллагааны хэрэгжилтээр		0.0						НБМ
140		"Архигүй Сэврэй" арга хэмжээг хэрэгжүүлэн, байгууллага бүр жилийн төлөвлөгөөндөө 2-оос доошгүй ажил төлөвлөн хэрэгжүүлж, гэмт хэргээс зөрчил, ажлын цагаар архи согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдолд хариуцлага тооцох, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх үйлдлийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлж тодорхой төрлийн гэмт хэрэг зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох замаар түүнээс урьдчилан сэргийлэх оновчтой үйл ажиллагааг зохион байгуулна.	үйл ажиллагааны хэрэгжилтээр		0.0						ХЭЗХМ
141		Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ханган ажиллаж нас, хүйс, хөгжлийн ялгаа гэх мэт аливаа төрлийн ялгаварлал, дарамт, хүчирхийллийг ажлын байр, олон нийтийн орчинд таслан зогсооход чиглэсэн арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.	үйл ажиллагааны хэрэгжилтээр		0.0						НБМ
	Дүн				**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	
3.4 Батлан хамгаалах салбарын чиглэлээр											
142		Дайчилгааны төлөвлөлтийг боловсронгуй болгож, дайчилгаа удирдах бүлэг, цугларах шилжүүлэх байрын бэлэн байдлын бэлтгэлийг дээшлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0	0					ЗДТГ-ын дарга
143		Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг сурталчлах, хүүхэд залууст эх оронч үзлийг төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0						ЗДТГ-ын дарга
144		Цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа иргэдийн сургалт, дадлага, бүтээлч ажлыг зохион байгуулж, цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийг төвлөрүүлэх.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0						ЗДТГ-ын дарга

145		Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулж, дайчилгааны төлөвлөгөөг тодотгон 2025 оны цэрэг татлагын ажлыг зохион байгуулж, цэргийн хяналтын тооны биелэлтийг хангах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0						ЗДТГ-ын дарга
146		Сумын гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгон мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг томилгоожуулан дадлагажуулах. Байгууллага иргэдийн идэвхийг өрнүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100	0						СӨК
147		Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлэх	Тухай бүрд нь	100	0						СӨК
	Дүн				**0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	
нийт дүн					**9069.8**	**0.0**	**7122.1**	**873.8**	**1033.9**	**40.0**	

Сэврэй сумыг 2025 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөө нь Бодлогын 3 хүрээнд 12 чиглэл 147 зааттайгаар батлуулахаар санал оруулж байна		
1		**Эрүүл мэндийн салбарын чиглэлээр 19 заалт**
2		**Боловсролын салбарын чиглэлээр 23 заалт**
3		**Соёл урлагын чиглэлээр 8 заалт**
4		**Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр 7 заалт**
5		**Төсөв санхүүгийн талаар 9 заалт**
6		**Хүнс хөдөө аж ахуйн, Үйлдвэрлэл худалдаа үйлчилгээний чиглэлээр 12 заалт**
7		**Дэд бүтцийн салбарын чиглэлээр 31 заалт**
8		**Байгаль орчин аялал жуулчлалын чиглэлээр 13 заалт**
9		**Төрийн захиргааны чиглэлээр 9 заалт**
10		**Хяналт шинжилгээ үнэлгээний чиглэлээр 4 заалт**
11		**Хууль эрх зүйн сургалт чиглэлээр 6 заалт**
12		**Батлан хамгаалах чиглэлээр 6 заалт**